



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тарагт сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/73/НА-СТА-ТШЗ**

|                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|---------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>Цахим хуудас:<br/><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br/>Арвайхээр<br/>2022 он</p> | <p>Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга,<br/>тэргүүлэх аудитор: О.Батжаргал<br/>Утас: 70323253      Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn<br/>Аудитын менежер: Д.Гансүх<br/>Утас: 70323833      Цахим хаяг: GansukhD@audit.gov.com<br/>Аудитор: Р.Энхзул<br/>Утас: 70323833      Цахим хаяг: EnkhzulR@audit.gov.mn</p> |
|---------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Аудитын тайлан .....
- 3.1 Ерөнхий зүйл .....
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Материаллаг байдал.....
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....
- 3.8 Аудитын гол асуудал.....
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
4. Аудитын илрүүлэлт.....
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

|          |                                                             |
|----------|-------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| ИТХ      | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал                                |
| НДШ      | Нийгмийн даатгалын шимтгэл                                  |

## 1. Аудитын дүгнэлт



### ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.01.14 № 59

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТАРАГТ СУМЫН ИТХ-Н  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Ш.ЭЛБЭГЖАРГАЛ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тарагт сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тарагт сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

015033117

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт                                                     | Эхний үлдэгдэл      | Эцсийн үлдэгдэл      |
|------------|-----------------------------------------------------------------------|---------------------|----------------------|
| <b>1</b>   | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                        | <b>910,000.00</b>   | <b>1,030,000.00</b>  |
| 35         | БАРАА МАТЕРИАЛ                                                        | 910,000.00          | 1,030,000.00         |
| 354        | Хангамжийн материал                                                   | 910,000.00          | 1,030,000.00         |
| 35420      | Аж ахуйн материал                                                     | 910,000.00          | 1,030,000.00         |
| <b>2</b>   | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>8,360,589.98</b> | <b>51,898,333.37</b> |
| 39         | ҮНДСЭН ХӨРӨНГӨ                                                        | 8,360,589.98        | 51,898,333.37        |
| 392        | Биет хөрөнгө                                                          | 8,349,589.98        | 51,898,333.37        |
| 39203      | Авто-тээврийн хэрэгсэл                                                | 22,000,000.00       | 46,480,000.00        |
| 39204      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (22,000,000.00)     | (1,355,666.69)       |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 6,399,600.00        | 6,399,600.00         |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (1,781,326.58)      | (2,720,016.50)       |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил                                           | 5,869,000.00        | 5,869,000.00         |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (2,147,683.44)      | (2,784,583.44)       |
| 39217      | Ном                                                                   | 10,000.00           | 10,000.00            |
| 393        | Биет бус хөрөнгө                                                      | 11,000.00           | -                    |
| 39301      | Програм хангамж                                                       | 165,000.00          | 165,000.00           |
| 39302      | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (154,000.00)        | (165,000.00)         |
| <b>3</b>   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>9,270,589.98</b> | <b>52,928,333.37</b> |
| <b>4</b>   | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                                                 | <b>-</b>            | <b>38,695.00</b>     |
| 41         | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР                                             | -                   | 38,695.00            |
| 413        | Өглөг                                                                 | -                   | 38,695.00            |
| 41310      | Ажилчидтай холбогдсон өглөг                                           | -                   | 38,695.00            |
| <b>5</b>   | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>9,270,589.98</b> | <b>52,889,638.37</b> |
| 51         | Засгийн газрын хувь оролцоо                                           | 9,270,589.98        | 52,889,638.37        |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 25,396,285.00       | 25,396,285.00        |
| 51101      | Өмч: - төрийн                                                         | 25,396,285.00       | 25,396,285.00        |
| 512        | Хуримтлагдсан үр дүн                                                  | (16,125,695.02)     | 27,493,353.37        |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн                                                    | (22,121,608.92)     | (16,125,695.02)      |
| 51220      | Тайлант үеийн үр дүн                                                  | 5,995,913.90        | 43,619,048.39        |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>9,270,589.98</b> | <b>52,928,333.37</b> |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт                                                                                                    | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|-------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|-----------------------|
| 1          | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                                                                             | 95,220,800.00       | 134,430,810.06        |
| 12         | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                                                                         | 400,000.00          | 46,480,000.00         |
| 120        | Нийтлэг татварын бус орлого                                                                                 | 400,000.00          | 46,480,000.00         |
| 120004     | Төсөв байгууллагын өөрийн орлого                                                                            | 400,000.00          | -                     |
| 1200045    | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                                                                           | 400,000.00          | -                     |
| 120017     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө                                                            |                     | 46,480,000.00         |
| 13         | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                                                                               | 94,820,800.00       | 87,950,810.06         |
| 1311       | Нэмэлт санхүүжилтийн орлого                                                                                 | 3,600,000.00        | -                     |
| 131103     | ЗГНХ ЗДНХөрөнгө, түүнтэй адиллах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,600,000.00        | -                     |
| 1320       | Орон нутгийн төсвөөс санхүүжих                                                                              | 91,220,800.00       | 87,950,810.06         |
| 132001     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/                                         | 91,220,800.00       | 87,950,810.06         |
| 2          | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН                                                                                 | 89,724,886.10       | 90,811,761.67         |
| 21         | УРСГАЛ ЗАРДАЛ                                                                                               | 89,724,886.10       | 90,811,761.67         |
| 210        | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                                                                             | 89,174,103.10       | 90,537,761.67         |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                                                                           | 65,459,768.00       | 64,165,682.63         |

Тарагт сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|             |                                                                             |                     |                      |
|-------------|-----------------------------------------------------------------------------|---------------------|----------------------|
| 210101      | Үндсэн цалин                                                                | 51,876,800.00       | 51,160,772.63        |
| 210104      | Урамшуулал                                                                  | 13,582,968.00       | 13,004,910.00        |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                       | <b>8,670,204.00</b> | <b>8,292,281.43</b>  |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                                          | 6,051,005.61        | 5,853,835.94         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал                                                          | 654,799.86          | 611,871.38           |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал                                                           | 523,799.46          | 489,496.95           |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                                        | 130,999.35          | 113,334.40           |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                                       | 1,309,599.72        | 1,223,742.76         |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                     | <b>4,592,036.00</b> | <b>5,033,800.00</b>  |
| 210401      | Бичиг хэрэг                                                                 | 514,700.00          | 1,071,500.00         |
| 210402      | Тээвэр, шатахуун                                                            | 3,658,970.00        | 3,549,300.00         |
| 210404      | Ном, хэвлэл                                                                 | 60,000.00           | 60,000.00            |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                                 | 358,366.00          | 353,000.00           |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>                                                     | <b>30,000.00</b>    | <b>-</b>             |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                                 | 30,000.00           | -                    |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                    | <b>-</b>            | <b>550,000.00</b>    |
| 210604      | Урсгал засвар                                                               | -                   | 550,000.00           |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                                               | <b>970,000.00</b>   | <b>960,000.00</b>    |
| 210702      | Дотоод албан томилолт                                                       | 970,000.00          | 960,000.00           |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>             | <b>736,075.00</b>   | <b>240,000.00</b>    |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж        | 237,300.00          | -                    |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                                    | 324,000.00          | -                    |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                                                  | 150,000.00          | -                    |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                               | 24,775.00           | -                    |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                             | -                   | 240,000.00           |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                      | <b>8,716,020.10</b> | <b>11,295,997.61</b> |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                             | 6,546,000.00        | 4,701,641.00         |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                           | 947,700.00          | 3,652,100.00         |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                          | 1,222,320.10        | 2,942,256.61         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                     | <b>550,783.00</b>   | <b>274,000.00</b>    |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                               | <b>328,000.00</b>   | <b>274,000.00</b>    |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                     | 328,000.00          | 274,000.00           |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b> | <b>222,783.00</b>   | <b>-</b>             |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг                                                       | 222,783.00          | -                    |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>                                   | <b>5,495,913.90</b> | <b>43,619,048.39</b> |
| <b>5</b>    | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                                              | <b>5,495,913.90</b> | <b>43,619,048.39</b> |

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Код | Үзүүлэлт                                         | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--------------------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|-------|-----------------------------------------|
| S01 | 2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл              | 25,396,285.00                   | 0.00                  | -16,125,695.02    | 0.00  | 9,270,589.98                            |
| S02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       |                                 |                       |                   |       | 0.00                                    |
| S03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                       | 25,396,285.00                   | 0.00                  | -16,125,695.02    | 0.00  | 9,270,589.98                            |
| S04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт          |                                 |                       |                   |       | 0.00                                    |
| S05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт        |                                 |                       |                   |       | 0.00                                    |
| S06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    |                                 |                       |                   |       | 0.00                                    |
| S07 | Тайлант үеийн үр дүн                             |                                 |                       |                   |       | 0.00                                    |
| S08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл            | 25,396,285.00                   | 0.00                  | -16,125,695.02    | 0.00  | 9,270,589.98                            |
| D01 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл              | 25,396,285.00                   | 0.00                  | -16,125,695.02    | 0.00  | 9,270,589.98                            |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00  | 0.00                                    |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                       | 25,396,285.00                   | 0.00                  | -16,125,695.02    | 0.00  | 9,270,589.98                            |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00  | 0.00                                    |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт                  | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00  | 0.00                                    |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00  | 0.00                                    |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү               | 0.00                            | 0.00                  | 0.00              | 0.00  | 0.00                                    |
| D08 | Тайлант үеийн үр дүн                             | 0.00                            | 0.00                  | 43,619,048.39     | 0.00  | 43,619,048.39                           |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл            | 25,396,285.00                   | 0.00                  | 27,493,353.37     | 0.00  | 52,889,638.37                           |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код  | Үзүүлэлт                                                                                                     | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>                                                                | <b>94,820,800.00</b>  | <b>87,950,810.06</b>  |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                                                         | <b>94,820,800.00</b>  | <b>87,950,810.06</b>  |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                                                           | 3,600,000.00          | -                     |
| 131103      | ЗГНХ ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,600,000.00          | -                     |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>                                                                        | 91,220,800.00         | 87,950,810.06         |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/                                          | 91,220,800.00         | 87,950,810.06         |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>                                                                 | <b>88,870,800.00</b>  | <b>87,950,810.06</b>  |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                                                         | <b>88,870,800.00</b>  | <b>87,950,810.06</b>  |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                                                       | <b>88,320,017.00</b>  | <b>87,625,810.06</b>  |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                                                                     | 65,459,768.00         | 64,126,987.63         |
| 210101      | Үндсэн цалин                                                                                                 | 51,876,800.00         | 51,122,077.63         |
| 210104      | Урамшуулал                                                                                                   | 13,582,968.00         | 13,004,910.00         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                                                        | 8,670,204.00          | 8,292,281.43          |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                                                                           | 6,051,005.61          | 5,853,835.94          |
| 210202      | Тэтгэмжийн даатгал                                                                                           | 654,799.86            | 611,871.38            |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал                                                                                            | 523,799.46            | 489,496.95            |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                                                                         | 130,999.35            | 113,334.40            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                                                                        | 1,309,599.72          | 1,223,742.76          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                                                                      | 4,547,670.00          | 4,368,000.00          |
| 210401      | Бичиг хэрэг                                                                                                  | 750,700.00            | 728,700.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун                                                                                             | 3,658,970.00          | 3,549,300.00          |
| 210404      | Ном, хэвлэл                                                                                                  | 60,000.00             | 60,000.00             |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                                                                  | 78,000.00             | 30,000.00             |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>                                                                                      | 150,000.00            | -                     |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл                                                                                  | 150,000.00            | -                     |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                                                     | -                     | 873,000.00            |
| 210604      | Урсгал засвар                                                                                                | -                     | 873,000.00            |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                                                                                | 970,000.00            | 960,000.00            |
| 210702      | Дотоод албан томилолт                                                                                        | 970,000.00            | 960,000.00            |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>                                              | 736,075.00            | 356,400.00            |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                         | 237,300.00            | 116,400.00            |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                                                                     | 324,000.00            | -                     |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                                                                                   | 150,000.00            | -                     |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                                                                | 24,775.00             | -                     |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                                                              | -                     | 240,000.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                                                       | 7,786,300.00          | 8,649,141.00          |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                                                              | 6,800,000.00          | 4,849,141.00          |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                                                            | 986,300.00            | 3,800,000.00          |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                                                      | <b>550,783.00</b>     | <b>325,000.00</b>     |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                                                                | 328,000.00            | 325,000.00            |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                                                      | 328,000.00            | 325,000.00            |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>                                  | 222,783.00            | -                     |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг                                                                                        | 222,783.00            | -                     |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>                                                      | <b>5,950,000.00</b>   | -                     |
| <b>5</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                                                             | <b>5,950,000.00</b>   | -                     |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                                                                      | <b>5,950,000.00</b>   | -                     |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>                                                                                   | 5,950,000.00          | -                     |
| 225106      | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                                                               | 5,950,000.00          | -                     |
| <b>6</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>                                   | <b>(5,950,000.00)</b> | -                     |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт                                                             | Тайлант оны           |               |
|-----------------------|----------------------------------------------------------------------|-----------------------|---------------|
|                       |                                                                      | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл     |
| <b>2</b>              | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             | 94,695,600.00         | 87,950,810.06 |
| <b>21</b>             | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                 | 94,695,600.00         | 87,950,810.06 |
| <b>210</b>            | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | 94,365,800.00         | 87,625,810.06 |
| <b>2101</b>           | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | 69,303,600.00         | 64,126,987.63 |
| 210101                | Үндсэн цалин                                                         | 54,240,000.00         | 51,122,077.63 |
| 210104                | Урамшуулал                                                           | 15,063,600.00         | 13,004,910.00 |
| <b>2102</b>           | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | 9,355,900.00          | 8,292,281.43  |
| 210201                | Тэтгэврийн даатгал                                                   | 6,583,800.00          | 5,853,835.94  |
| 210202                | Тэтгэмжийн даатгал                                                   | 693,600.00            | 611,871.38    |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал                                                    | 553,900.00            | 489,496.95    |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал                                                 | 138,500.00            | 113,334.40    |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал                                                | 1,386,100.00          | 1,223,742.76  |
| <b>2104</b>           | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | 4,368,000.00          | 4,368,000.00  |
| 210401                | Бичиг хэрэг                                                          | 728,700.00            | 728,700.00    |
| 210402                | Тээвэр, шатахуун                                                     | 3,549,300.00          | 3,549,300.00  |
| 210404                | Ном, хэвлэл                                                          | 60,000.00             | 60,000.00     |
| 210406                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 30,000.00             | 30,000.00     |
| <b>2106</b>           | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | 873,000.00            | 873,000.00    |
| 210604                | Урсгал засвар                                                        | 873,000.00            | 873,000.00    |
| <b>2107</b>           | <b>Томиллолт, зочны зардал</b>                                       | 970,000.00            | 960,000.00    |
| 210702                | Дотоод албан томиллолт                                               | 970,000.00            | 960,000.00    |
| <b>2108</b>           | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 845,300.00            | 356,400.00    |
| 210801                | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 116,400.00            | 116,400.00    |
| 210802                | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 314,300.00            | -             |
| 210804                | Тээврийн хэрэгслийн татвар                                           | 145,500.00            | -             |
| 210805                | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                        | 29,100.00             | -             |
| 210806                | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 240,000.00            | 240,000.00    |
| <b>2109</b>           | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 8,650,000.00          | 8,649,141.00  |
| 210901                | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 4,850,000.00          | 4,849,141.00  |
| 210902                | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 3,800,000.00          | 3,800,000.00  |
| <b>213</b>            | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                              | 329,800.00            | 325,000.00    |
| <b>2132</b>           | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                        | 329,800.00            | 325,000.00    |
| 213209                | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 329,800.00            | 325,000.00    |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилт байхгүй.

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Тарагт сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Р.Энхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тарагт сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймгийн Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 02/01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Тарагт сумын ИТХ-ын зорилго нь нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тарагт сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 89537.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 895.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувь буюу 716.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянан шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө болон бараа материалын тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 24480.0 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй авсан 46480.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл нэмэгдэж, 22000.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.
- Бараа материал оны эхнээс 120.0 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан дуу хураагчаар аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 104876.7 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 87950.8 мянган төгрөгөөр батлагджээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайланд оны төсөв 87950.8 мянган төгрөгөөр батлагдаж, 87950.8 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн ба гүйцэтгэл 87950.8 мянган төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилт байхгүй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

### **3.8 Аудитын гол асуудал**

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэхэд НДШ-ийн тайланд 217.9 мянган төгрөгийн цалин хөлсийг дутуу тайлагнасан, 421.7 мянган төгрөгийн шатахууны тайлангийн анхан шатны баримт дутуу, шинээр ирсэн автомашины тайлант оны элэгдлийг бодуулаагүй, шинээр худалдан авсан 120.0 мянган төгрөгийн дуу хураагчийг зарлагдсан, нийгмийн даатгалын тайланд цалин хөлсийг дутуу тайлагнаснаас үүссэн өглөг тусгаагүй зэрэг зөрчил илэрлээ.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тарагт сумын ИТХ нь шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 144 мэдээллийг хугацаанд нь, хугацаа болоогүй 4 мэдээлэл, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалин урамшуулал илүү олгосонтой холбоотой алдаа зөрчилд 600.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй 6900.0 мянган төгрөгийн албан шаардлага өгсөн бөгөөд акт, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 сарын 16-ны өдрийн 01/16 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй.

### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2154.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн.

#### 4.1 Залруулга

Шинээр ирсэн автомашины тайлант оны элэгдлийг бодуулаагүй, шинээр худалдан авсан 120.0 мянган төгрөгийн дуу хураагчийг зарлагдсан, НДШ-ийн тайланд цалин хөлсийг дутуу тайлагнаснаас үүссэн 38.7 мянган төгрөгийн өглөгийг тайланд тусгаагүй байсныг тус тус залруулсан.

#### 4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

#### 4.3 Албан шаардлага

Нийгмийн даатгалын тайланд 217.9 мянган төгрөгийн цалин хөлсийг дутуу тайлагнасан, 421.7 мянган төгрөгийн шатахууны тайлангийн анхан шатны баримт дутуу зөрчилд албан шаардлага өгсөн.

#### 4.4 Зөвлөмж

Зөвлөмж байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |        | Үүнээс    |        |               |     |                 |       |         |     |
|-----|-------------------------------------|----------------------|--------|-----------|--------|---------------|-----|-----------------|-------|---------|-----|
|     |                                     |                      |        | Залруулга |        | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |       | Зөвлөмж |     |
|     |                                     | Тоо                  | Дүн    | Тоо       | Дүн    | Тоо           | Дүн | Тоо             | Дүн   | Тоо     | Дүн |
| 1   | Тарагт сумын ИТХ                    | 5                    | 2154.0 | 3         | 1514.4 |               |     | 2               | 639.6 |         |     |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Р.ЭНХЗУЛ